

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
9 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2021 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хуралдаж Сумдын багийн нэр дугаарыг хэлэлцэн, уламжлах тухай, Аймгийн Мал аж ахуйн салбарын бодлого, чиглэл батлах тухай, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам батлах тухай, Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам батлах тухай, Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнуулах тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажлын хэсэг Чулуут, Ихтамир, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Цэнхэр, Хотонт, Төвшрүүлэх, Өндөр-Улаан, Тариат, Хангай, Цахир сумдад ажиллан сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

“Орон нутагт ажиллуулах тухай” Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 168 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг 2021 оны 9 дүгээр сарын 13-наас 15-ны өдрүүдэд Архангай аймагт ажиллаж, удирдамжийн дагуу төрийн захиргааны 20 байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа, төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийлээ.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд дараах 6 арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

1. Ажлын хэсэг орон нутгийн удирдлагуудтай уулзаж (аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга) өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж буй талаархи мэдээлэл, тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг сонссон.

2. Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны шинэтгэлийн бодлогын хэрэгжилттэй танилцаж, тулгамдаж буй асуудлуудын талаар санал хүсэлт сонсож тодорхой чиглэл өгсөн.

3. Иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр төрийн албан хаагчдад цахим сургалт зохион байгуулсан. Цахим сургалтад аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын Тамгын газрын 81 төрийн албан хаагч оролцсон.

4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 18 агентлаг, нийт 20 байгууллагын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. 20 байгууллагын 415 төрийн захиргааны албан хаагчийн сонгон шалгаруулалт, томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд нийт зөрчилтэй томилгоо 108, үүнээс Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай

хуулийг үндэслэн хийсэн томилгоо 18, тусгай шалгалт өгөөгүй томилогдсон томилгоо 105, ерөнхий шалгалт өгөөгүй томилогдсон томилгоо 40 байна.

5.Төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх зорилгоор 40 төрийн жинхэнэ албан хаагчаас 30 минутын тусгай шалгалт авсан. Тусгай шалгалтад төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 40 албан хаагч оролцсон.

Мөн орон нутгийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээний талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.

6. Орон нутагт төрийн байгууллагуудад олон жил ажилласан ахмадуудын сургаал, санал, зөвлөмжийг сонсох үйл ажиллагааг ажиллагааг зохион байгуулсан.

7. Төрийн албаны тухай хуулийг зөрчин томилогдсон төрийн жинхэнэ албаны 8 удирдах албан тушаалтанд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийсэн.

Жил бүрийн намар уламжлал болгон зохион байгуулдаг “Намрын ногоон өдрүүд” нэгдсэн арга хэмжээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас 9 дүгээр сарын 16-наас 23-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. 15 дахь жилтэйгээ золгож байгаа тус арга хэмжээнд нийт 400 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцож, өөрсдийн ур ухаан, хүч хөдөлмөр, сэтгэл зүрх, цаг хугацаагаа зориулан бүтээсэн төрөл бүрийн бүтээгдэхүүнээ танилцуулан худалдаалж, иргэд олон нийт ч идэвхтэй оролцож, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих сайхан арга хэмжээ болсон ба Архангай аймгийн Хотонт, Ихтамир, Чулуут, Тариат сумдаас гар урлал, сүү цагаан идээний төрлөөр 1 аж ахуйн нэгж, 3 иргэн оролцсон.

Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-ын Элчин сайдын яам, Иргэн цэргийн харилцааны дэмжлэгийн багтай хамтран “Хангай-21” гамшгийн хор уршгийг арилгах хамтарсан туршлага солилцох сургалт, дадлага сургуулийг 9-р сарын 12-наас 24-ний өдрүүдэд Архангай аймагт зохион байгууллаа.

“Хангай-21” гамшгийн хор уршгийг арилгах хамтарсан дадлага сургууль нь Монгол Улсад 2009 оноос хойш тасралтгүй зохион байгуулж ирсэн “Говийн чоно” сургалт, дадлага сургуулийн үргэлжлэл бөгөөд энэ жил 10 дахь удаагаа боллоо. “Говийн чоно” сургалт дадлагад 2017 онд 13 улс, 2018 онд 16 улс, 2019 онд 21 улс орны төлөөлөл оролцож байсан бөгөөд энэ удаагийн сургалт дадлагад АНУ, БНТУ, БНСУ, Япон улсын зочид төлөөлөгчид оролцсон юм.

Сургалтыг АНУ-ын Иргэн цэргийн харилцааг дэмжих багийн сургагч багш нар удирдан явуулж, ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад, Давтан сургалт, сургалт сэргээн заслын төв-113 дугаар анги, НОБГ, Өмнөд бүсээс Өвөрхангай, баруун бүсээс Завхан, хойд бүсээс Архангай, Булган, Хөвсгөл аймгуудын Онцгой байдлын газрын алба хаагчид хамрагдсан юм. Сургалт, дадлага сургууль, туршлага солилцох үйл ажиллагаа нь “Гамшгийн удирдлага”, “Команд штабын дадлага”, “Өндрөөс аврах олсны сургалт”, “Давчуу орон зайнаас аврах ажиллагаа”, “Нурангинаас аврах ажиллагаа”, “Хээрийн эмнэлэг дэлгэх үйл ажиллагаа”, “Нэрвэгдэгчийг эрэмбэлэн ангилалт”, “Олон нийттэй харилцах”, “Хүмүүнлэгийн тусламжийн үеийн цэргийн дэмжлэг”, “Дууриалган үзүүлэх дадлага сургууль” гэсэн хэлбэрээр зохион байгуулсан.

Дадлага сургуулийн хүрээнд 5 төрлийн техникийн болоод онолын сургалт, “Өндрөөс аврах олсны сургалт”, “Давчуу орон зайнаас аврах ажиллагаа”, “Эмнэлгийн тусламж болон эрэмбэлэн ангилалт” сэдэвт сургалтууд боллоо.

Танхимын сургалтаар гамшгийн удирдлагын онол, онцгой байдлын удирдлагын төв, гэнэтийн ослын удирдлагын системийн талаар мэдээллийг оролцогч нарт өгч

дээрх сургалт дөрвөн өдөр үргэлжиллээ. Сургалтад 6 аймгийн Онцгой байдлын газрын дарга, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, онцгой комиссын гишүүд хамрагдав.

2021 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаар сүүлийн 24 цагт PCR шинжилсэн 241 сорьцноос 83, түргэвчилсэн оношлуурын 173 шинжилгээнээс 58, нийт 141 тохиолдол батлагдсан байна. Тодруулбал, Ихтамир 4, Чулуут 12, Хангай 3, Тариат 2, Өндөр-Улаан 7, Эрдэнэмандал 4, □Жаргалант 14, Цэцэрлэг 2, Хайрхан 6, Өлзийт 2, Өгийнуур 2, Хашаат 4, Хотонт 7, Цэнхэр 3, □Төвшрүүлэх 3, Эрдэнэбулган 66, батлагдсан тохиолдлын тоо нийт 7970 болсон байна.

Тусгай эмнэлгүүдээс 91, өрхийн эмнэлгийн хяналтад гэрээр эмчлүүлж 54 хүн, нийт 145 хүн эдгэрсэн байна. Нийт 7970 тохиолдлын 6807 нь буюу 85.4% нь эдгэрсэн, нийт нас баралт 23 байна.

Эмчлүүлж байгаа 1155, үүнээс 24 тусгай эмнэлэгт 773, Биеийн байдал хөнгөн 600, хүндэвтэр 145, хүнд 23, маш хүнд 5. ӨЭМТ-үүдийн хяналтад гэрээр эмчлэгдэж байгаа 405, Ар Мөнгөнчагнуур 205, Ар Мөнхжин 106, Ар Манал 94, насны хувьд авч үзвэл 0-5 насны 145, 6-15 насны 182, 16-39 насны 418, 40-59 насны 298, 60-аас дээш насны 112 эмчлүүлэгч байна. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын гэрийн тусгаарлалтад байгаа хүн – 2696. Аймгийн хэмжээнд I тунд 60245, II тунд 56080, III тунд 7076 хүнийг хамруулж дархлаажуулсан байна.

Аймгийн хэмжээнд дэлгэсэн тусгай эмнэлэг 24, дэлгэсэн ор 660, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдварын улмаас нийт эмчлүүлж байгаа хүн 1155, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгч 773, ӨЭМТ-ийн хяналтанд гэрээр эмчлэгдэж байгаа хүн 405, Нийт 7970 тохиолдлын 6807 нь буюу 85.4% эдгэрсэн байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт

2021 оны 9 дүгээр сард орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 353.0 сая төгрөг, аймгийн төсөвт 943.9 сая төгрөг төвлөрүүлэхээр ажиллаж байна. Татварын хууль тогтоомж, татварын тайлан гаргах, цахимаар татвар төлөлтийн талаар 4 мэдээллийг бэлтгэн Архангай аймгийн Татварын Хэлтсийн пэйж хуудсанд байршуулж, 91 татвар төлөгчид утсаар зөвлөгөө өгч, ибаримтын нэвтрэх нэр, нууц үг авах хүсэлт гаргасан 39 татвар төлөгчид нэвтрэх нэр нууц үгийг олгож, угтах үйлчилгээнээс 63 татвар төлөгчид зөвлөгөө өглөө. Малын тоо толгойн албан татварын хуулийг 9 сумын 29 багийн иргэдэд сурталчилж, 53984.7 мянган төгрөгийн албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Хөрөнгө оруулалт

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 6.581.178.1 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 483.809.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн өмчит 29 төсөвт байгууллагад 52.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 5 төсөвт байгууллагад 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, 22 байгууллагад 364 нэр төрлийн 364.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрлийг тус тус олгосон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хувьчлахаар шийдвэрлэсэн үл хөдлөх хөрөнгийн нийтийн дуудлага худалдааг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулж, 1 барилгыг дуудлага худалдаагаар худалдаж, орон нутгийн төсөвт 2.5 сая төгрөг төвлөрүүлэхээр болсон.

2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 100.0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 130.0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, сумын орон нутгийн хөгжлийн сантай хамтарсан 348.2 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сангийн 769.0 сая төгрөгний 7 төсөл арга хэмжээ, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 30.0 сая төгрөгний өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ, Захиалгат ажил 1.337.0 сая төгрөгний 2 төсөл арга хэмжээний худалдан авалтыг тус тус зохион байгуулан, тендер зарлаж, цахим системд байршуулсан.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1.600.0 сая төгрөгний өртөг бүхий Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил, Өндөр-Улаан, Чулуут сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 160.0 сая төгрөгний зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 901.2 сая төгрөгний өртөг бүхий 5 төсөл арга хэмжээний ажлын тендерт нэг ч аж ахуйн нэгж тендер ирүүлээгүй тул дахин зарласан. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Өгийнуур сумын Орхон голын модон гүүр барих ажлын тендерийг 2 удаа зарласан боловч нэг ч аж ахуйн нэгж тендер ирүүлээгүй тул хуулийн дагуу захиалагчид зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн хяналт

Хайрхан, Жаргалант сумын төсөвт албан байгууллагуудын 2019-2020 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж, Жаргалант суманд 129.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс улсын ахлах байцаагчийн 6 төрлийн актаар 39.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 1 актаар 3.9 сая төгрөгийг тухайн байгууллагад төвлөрүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоон шийдвэрлэж, улсын байцаагчийн 2 албан шаардлагаар 86.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, Хайрхан суманд улсын ахлах байцаагчийн 5 төрлийн актаар 23.8 сая төгрөгийн төлбөр, 18.2 төгрөгийн зөрчилт үйлдлийг таслан зогсоохоор хугацаатай үүрэг чиглэл тус тус өгч ажиллалаа. Эрүүл мэндийн салбар байгууллагуудын 2020-2021 оны үйл ажиллагаанд дотоод аудит, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2019-2020 оны үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын ажил эхлээд байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд Хууль, хяналт

2021 оны 9 дүгээр сард 2 удаагийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол тохиолдсоноос объектын гал түймэр 2 дуудлага ирсэн байна.

Аймаг, орон нутгийн хэмжээнд, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвар өвчилсөн иргэдийг Нэгдсэн эмнэлгийн болон 18 сумын эрүүл мэндийн төвүүдийн тусгайлсан эмнэлэгт тусгаарлан эмчилгээ хийж, Эрдэнэбулган сумын өрхийн эрүүл мэндийн төвүүд хөнгөн туссан иргэдийг гэрээр тусгаарлан хяналт тавьж, эмчилгээ хийж ажиллаж байна. Халдвар авсан иргэдийн ойрын болон дам хавьтлуудыг

тандалт судалгаа хийж илрүүлэн “PCR”-ын шинжилгээг авч гэрээр тусгаарлан, биеийн байдал тогтворгүй, шинж тэмдэг нь сэжигтэй тусгаарлах зайлшгүй шаардлагатай иргэдийг тусгаарлан 7 хоног гэрт нь байрлуулж давтан шинжилгээ авч шинжилгээний хариуг үндэслэн дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвар урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, орон нутгийн хэмжээнд бороо, ус их байгаатай холбогдуулан үер усны ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 8545 иргэнд хүрч хандалт авсан байна.

2021 оны 8-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 242 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 81, хулгайлах гэмт хэрэг 70, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 18, малын хулгайн гэмт хэрэг 33, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 12, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 68, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 25, гэмт хэргийн илрүүлэлт 37.6 хувьтай байна.

Нийт 13532 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 12941 иргэнд 492234.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 614.5 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 54.1 хувьтай байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 6 хяналтын чиглэлээр Ихтамир, Булган, Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэмандал сумдын 30 объектод төлөвлөгөөт шалгалт, 16 объектод зөвлөн туслах үйлчилгээг тус тус хийж, мэргэжил арга заавар зөвлөгөө өгч ажилласан байна. Ургац хураалтын явц байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 10 сумын 48 аж ахуй нэгж, иргэнийг хамруулж хийлээ. Шалгалтаар 40 зөрчлийг илрүүлж, газар дээр нь 8 зөрчлийг арилгуулж, 32 заалт бүхий 4 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. 48 аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаанд үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгсөн байна. Аймгийн хэмжээнд ургац хураалт 7%тай байна.

Мэргэжлийн хяналтын газрын лабораторид ирүүлсэн 18 иргэн, аж ахуй нэгжийн 46 нэр төрлийн хүнсний ногооны дээжинд 262 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд стандартын шаардлагыг хангасан дүнтэй, 8 төрлийн жимс, жимсгэнэ, улаан буудайн 2 дээжинд шинжилгээ хийж байна.

Эрдэнэмандал, Жаргалант, Ихтамир, Цэцэрлэг, Булган сумдын Эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, Ковид-19 шинжилгээ авах цэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч, сумын удирдлага болон Шуурхай штабын гишүүдэд орон нутгийн хэмжээнд цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Мөн Ихтамир сумын зам дагуу хоол үйлдвэрлэлийн 5 цайны газар, Эрдэнэбулган сумын 38 хүнс, худалдааны цэг салбарын халдвар хамгааллын дэглэмийн байдалд шалгалтыг хийж, 38 зөрчлийг илрүүлж газар дээр 28 зөрчлийг арилгуулан ажилласан,

2021-2022 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангуулахаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Эрдэнэбулган сумын 5 сургууль 14 цэцэрлэгт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. ЕБС, СӨБ-ын унд ахуйн хэрэглээний усыг аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторид 33 цэцэрлэг 23 сургуулийг 100% хамруулж стандартын шаардлага хангууллаа.

Мэргэжлийн хяналтын газрын лаборатори нь Стандартчилал, техникийн зохицуулалт тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу олгогдсон

итгэмжлэлийн хүрээнд заагдсан 72 нэр төрлийн 346 үзүүлэлтээр гүйцэтгэн сорилтын үр дүнг цаг хугацаанд нь холбогдох байцаагчид болон иргэн, аж ахуйн нэгжид хүлээлгэн өгч байна.

2021 оны 9 сарын байдлаар 239 сорьц 636 үзүүлэлтийг Gasi.shinjilgee.mn хаягаар бүртгэн сорилт шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна.Төлөвлөгөөт 227 сорьц 591 үзүүлэлтээр 3682100 төгрөгийн шинжилгээг хийж үр дүнг холбогдох байцаагчдад хүлээлгэн өглөө. Аж ахуйн нэгж иргэний хүсэлтээр ирсэн 12 сорьц 45 үзүүлэлтээр 339300 төгрөгийн сорилт шинжилгээг хийж, үр дүнг холбогдох хүмүүст танилцуулсан.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс 9-р сард Эрдэнэбулган сум, Булган сум, Ихтамир сум, Тариат сум, Жаргалант сум, Цэцэрлэг сумдын жижиглэн худалдаа эрхлэгч-10, хоол үйлдвэрлэл эрхлэгч-2 дээрх 12 үйлчилгээний газрууд Тохирлын гэрчилгээ сунгах хүсэлт ирүүлсэний дагуу үнэлгээ хийж, баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн 8 үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосон.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Эрүүл мэнд

Дархлаажуулалтын ээлжит 10 хоногийг “Улирлын томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулж, улирлын томуугийн эсрэг вакцинжуулалтад 2-11 насны хүүхдүүд болон жирэмсэн нийт 3311 хүнийг хамруулсан.

9-р сарын 01-ний өдөр аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүдийн төлөөлөлтэй уулзаж, Ковид-19 халдвартай өвчтөн эрэмбэлэх, хэвтүүлэн эмчлэх, ӨЭМТ-ийн хяналтад гэрээр эмчлэх явцад тулгарч байгаа асуудлууд, нөхцөл байдлын талаар ЭМГ, НЭ, ӨЭМТ-үүдийн эмч, мэргэжилтний төлөөлөл 09-р сарын 02-ны өдөр уулзалт ярилцлага зохион байгуулж, саналаа солилцсон. Уулзалтад оролцсон эмч нар дараах тулгамдаж байгаа асуудлуудыг танилцуулсан бөгөөд, эдгээр тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор 4 арга хэмжээнд зохицуулалт хийж ажиллахыг НЭ-ийн даргад даалгасан.

Эрүүл мэндийн байгууллагуудын ковидын үеийн тусламж үйлчилгээний бэлэн байдал нөөцийн үнэлгээг 2 удаа хийж, Аймгийн Засаг даргад 2 хүсэлтийг хүргүүлж, сумын эрүүл мэндийн төвүүдэд 1 удаа, сумдын Засаг дарга нарт 2 удаагийн чиглэлийг хүргүүлсэн.

2020-2021 оны хичээлийн жилийн төгсөлтийн дараах сургалтад уушги судлал 1 эмч, яаралтай тусламж судлал 1 их эмч, сэхээн, яаралтай тусламж судлалд тус бүр 1, ариутгагчийн сургалтад 9 сувилагч тусгай мэргэжилтэнийг 09 сарын 01-нээс хамруулсан. 10 сарын 01-ны сургалтад 2 их эмч, 8 сувилагч тусгай мэргэжилтэнийг хамруулахаар бүртгэлийг ЭМХТ-д хүргүүлсэн.

КОВИД-19 цар тахлын цар хүрээ нэмэгдэн, цар тахлын тархалтын түвшинг “улаан” түвшинд шилжиж, эрүүл мэндийн ажилтнууд өвчилж байгаа тул эмнэлгийн ажилчдын дархлааг дэмжих зорилгоор 32 байгууллагын 1110 ажилтанд нийт 8,199,500 /найман сая нэг зуун ерэн есэн мянга таван зуун/ төгрөгийг “Дархлаажуулалтын багц”-ыг хуваарилсан.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2021 оны 9 сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 866 иргэн бүртгэлтэй байгаагаас 431 эмэгтэй. Шинэ ажлын байр 694 үүнээс байнгын ажлын байр 348, улирлын ажлын байр 174, түр ажлын байр 172 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 604, зуучлал 577 байна. Тухайн сарын 20-ны байдлаар 208 иргэн нь шинээр бүртгүүлж,

LMIS программд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 11, бага- 23, суурь-137, бүрэн дунд- 493, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 19, тусгай мэргэжлийн дунд-23, Дипломын бакалаврын-160 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Тухайн сард ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 29 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч ЭМНДХэлтэс рүү хүргүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийг түшиглэн Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх арга хэмжээг туршилтаар хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт ажил хайгчаар бүртгүүлсэн, мэргэжил эзэмшсэн, ажлын туршлагагүй эсвэл туршлага багатай 34 хүртэлх насны 23 залууг хамруулж модуль сургалтанд хамрууллаа.

Оролцоо төслийн эхний ээлжийн сургалтанд 49 залуу 14 хоногийн сургалтанд амжилттай оролцон 9 сарын 15,16-ны өдрүүдэд сум, орон нутагтаа эргэн ирж дараагийн ээлжийн 8 залуу 14 хоногийн сургалтанд хамрагдахаар Улаанбаатар хотыг зорилоо. Сургалтанд хамрагдсан 49 залуус ажил амьдралын гараагаа зөв эхлүүлэх, зорилгоо тодорхойлох, өөрийгөө илэрхийлэх, хөдөлмөр эрхлэх чадвар, чиг баримжаатай болж, дараагийн арга хэмжээ болох 14 хоног дадлага хийх ажил олгогч байгууллагуудыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас санал болгосноор ажлын байранд дадлагажин ажлын гараагаа эхлүүллээ.

Ургац хураалтанд аймгийн хэмжээнд 151 иргэнийг 36 аж ахуй нэгж, байгууллага, иргэнд жимс жимсгэнэ түүх, ногоо хураах ажилд зуучлан түр ажлын байраар хангалаа.

2021 оны 9 сарын байдлаар нийт 16447 тэтгэвэр, тэтгэмж авагчдад 44.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн хугацаанд шуурхай олгож ажилласан байна.

Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2021 оны 7-р сарын 20-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар баталсан “Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх”- аяныг 2021 оны 7-р сарын 05-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд Мал аж ахуй

Засгийн газрын 2021 оны 7-р сарын 28-ны өдрийн 221 дүгээр тогтоол “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай”, Монгол Улсын Шадар сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх” тухай 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” албан даалгаврын хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд малчдын түвшинд 80.0 мянган тн өвс, 1300 тн гар бэлтгэхээс өнөөдрийн байдлаар 41.2 мянган тн өвс, 652 тн гар тэжээлийг бэлтгэн хадлан бэлтгэл 52 хувьтай байна. Аймаг сумын аюулгүйн нөөцөд 2950 тн өвс, 1100 тн тэжээл, 400 тн ногоон тэжээл бэлтгэхээс 77 тн өвс, 5.1 тн тэжээл бэлтгэн бэлтгэл 3 орчим хувьтай байна.

Засгийн газраас өвөлжилтийн бэлтгэл хангахад сум бүрт 15 сая, аймагт 700 орчим сая төгрөгийн нийт 1 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Энэ жил аймгийн хэмжээнд 9149 хот айлын 17,6 мянган малчин өрхийн 5,399 мянган толгой мал өөрийн аймгийн нутагт өвөлжиж, хаваржина. Чулуут, Хангай,

Цэнхэр, Булган сумдын 244 малчин өрхийн 95.8 мянган толгой мал Улсын тусгай хамгаалалтай газарт өвөлжиж, хаваржина.

Энэ онд бог малын 24100 толгой хээлтүүлэгч мал, 2385.0 мянган толгой хээлтэгч мал тоологдсон. Тохироогоор 11356 толгой хуц, 4571 толгой ухна нийт 15927 толгой богийн хээлтүүлэгч мал дутагдалтай байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 10 нэгжид 3259 хуц, 828 ухна нийт 4087 хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлсэн байна. Энэ онд 2409 толгой богийн хэлэтүүлэгчийг шинээр нөхөн тавиад байна.

Газар тариалан

Архангай аймаг Улаанбуудай ангилсан 700 га талбай, цайруулсан 500 га талбайгаас 700 тн, шууд хураалт 300 га талбайгаас 420 тн, овьёос, тосны ургамлын хураалт хараахан эхлээгүй, тэжээлийн ургамлыг дөнгөж унагаж эхэлж байна. Төмс 130 га талбайгаас 1010 тн, хүнсний ногоо 110 га талбайгаас 870 тн хураасан байна.

Намрын ургац хураалтанд ажиллах техник засварын ажил хийгдэж комбайн-1, хадагч-12, будаа цэвэрлэгч-2, үр сортлогч-5, будаа ачигч-7, төмсний комбайн-1, төмс сортлогч-1, төмс ухагч-8 зэрэг 8 нэр төрлийн 50 техник хэрэгсэл, 218 хүн хүч ажиллаж байна.

Үр тарианы ургамлын тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авсан дүнгийн нэгтгэлийг авч үзвэл 10400 га талбайд тариалснаас 2307 га буюу 22,8% нь соёололт онц, 5830 га буюу 57,7% нь сайн, 1963,4 га буюу 19,4% нь дунд зэргийн байсан бөгөөд үр тарианы соёололтын үед хур тунадасны хэмжээ багасаж байсан бол сүүлийн өдрүүдэд үргэлжилсэн зөөлөн бороо орсноор хөрсний чийг сайжирч, ургамлын өсөлт хөгжилтөд сайнаар нөлөөлсөн гэж үзэж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Барилга, дэд бүтэц, газар

Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилгуудад 2021 оны 9-р сард барилгын мэргэилтэн, захиалагч инженерүүдийг 6 ээлжээр зохион байгуулж үе шатны хяналтын ажлыг зоаин байгуулж 50 гаруй барилгад үе шатны хяналтын ажлыг хийлээ. Хяналтын хийсэн ажлын тайланг танилцуулан ажил удаашралтай байгаа Хашаат, Өлзийт сумын сургуулийн барилга угсралтын ажил, Жаргалант сумын сургуулийн барилгын засварын ажилд даргын албан тоотоор ажил сайжруулах мэдэгдэл хүргүүлээд байна.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх чиглэлээр Цэцэрлэг сумын 25 барилга, Эрдэнэмандал сумын 10 барилгын мэдээллийн цаасан хэлбэрээр бүрдүүлээд байна.

Барилгын материалын лаборатори нь 2021 оны 9-р сарын байдлаар давхардсан тоогоор 57 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 122 дээжинд сорилт шинжилгээ хийн 113 дээжийн үр дүнг хүлээлгэн өгч 100010029401 тоот дансанд 2874000 төгрөг төвлөрүүлээд байна.

Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ

Хүнсний нөөцийн сүүлийн 7 хоногийн судалгаагаар гурил 368.8 тн буюу 47 хоног, гоймон 35.8 тн буюу 3 хоног, будаа 78.9 тн буюу 21 хоног, сахар 70.5 тн буюу 28 хоног, ургамлын тос 20.18 тн буюу 10 хоног, давс 34.3 тн буюу 82 хоног, ундны ус 41.28 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 5.36 тн буюу 4 хоног, төмс 36.7 тн буюу 14 хоног, хүнсний ногоо 18.8 тн буюу 1 хоног, өндөг 1.22 тн буюу 20 хоногийн нөөцтэй байна.

Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд “Ажлын байрыг дэмжих” зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байна. Үүнд:

- “Хаан” банк 117 иргэн, аж ахуйн нэгжид 7,4 тэрбум төгрөг,
- “Төрийн” банк 46 иргэн, аж ахуйн нэгжид 9.0 тэрбум төгрөг,
- “Хас” банк 21 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 тэрбум төгрөг,
- “Голомт” банк 20 иргэн, аж ахуйн нэгжид 1,4 тэрбум төгрөгийн зээлүүдийг тус тус олгосон.

Ажлын байрыг дэмжих зээлийг 353 иргэнд 11,7 тэрбум төгрөг, 64 аж ахуйн нэгжид 9,7 тэрбум төгрөг, нийт 417 иргэн, аж ахуйн нэгжид 21,4 тэрбум төгрөгийн зээл олгож 823 ажлын байрыг хадгалсан байна.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийг олгож эхлээд байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 1161 малчинд 14,2 тэрбум төгрөг, газар тариалангийн чиглэлээр 3 иргэн, аж ахуйн нэгжид 160.0 сая төгрөгийн зээл тус тус олгоод байна.

2020 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт жилийн эцсийн байдлаар 700.8 сая төгрөг орж ирсэн бол 2021 оны сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт энэ оны эхний хагас жилийн байдлаар 989,3 сая төгрөг орж ирсэн байна. 2020 онд сум хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийг Цэнхэр, Хангай, Өндөр-Улаан сумын 65 иргэн, аж ахуйн нэгжийн төсөлд 240.0 сая төгрөгийн зээл олгож 98 ажлын байр бий болсон байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oOo-----